

**БАТЛАВ**

**ЗАХИРАЛ**

**С.ОТГОНГЭРЭЛ**

**МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН VII АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

**А ХУВИЛБАР**

**Батсүх багш**

Ангийн хаалга нээгдэж Батсүх багш минь орж ирэх минь ертөнцийн хаалга нээгдэж, Бурхан багш залрах лугаа адил бөлгөө. Батсүх багш минь хичээл зааж байхад түүнээс гэрэл цацрах мэт байдаг сан. Түүний цээл сайхан хоолой тасалгаа дүүрэн цуурайтаж, бид түүний чин зүрхний үг, дуу хоолойн аялга, хөдөлгөөн бүхэнд олзлогдож, түүнтэй өнгөрүүлсэн агшин бүр энэ ертөнцөөс бидэнд заяасан нэгэн их билиг, хайр хишиг болдог байлаа. Түүнийг ярьж байхад бид ширүүхэн амьсгалахаас ч айдаг байлаа. Тэр бол ер бусын агшин юм. Түүнийг гарч одоход биднээс ямар нэгэн юм тасран салах шиг болоод гунигтай, түүнийг орж ирэхэд нэг ангийн гучин хэдэн хүүхэд түүнтэй нэгдэж, нэгэн амь, нэгэн бие, нэгэн санаа болон хувирах бөлгөө.

Жинхэнэ багш гэгч ийм буюу. Өнөө ч бид ямар нэгэн муу юм хийхдээ Батсүх багш минь дуулчих вий гэж эмээх бөгөөд сайн юм хийхдээ ганц тэр минь л сонсоосой гэх бөлгөө.

1. Эхийн гол санааг илэрхийлэн өөрийн үгээр дэлгэрэнгүй тайлбарлан бичнэ үү.

/2 оноо/

.....  
.....  
.....  
.....

2. Дараах хэлцүүдийг утга санаатай нь зөв харгалзуулаарай? /2 оноо/

- |                                   |                       |
|-----------------------------------|-----------------------|
| 1. Хүйтний ам цаашаа харж         | В. Яаруу, бүтэлгүйтэх |
| Хөхүүрийн ам наашаа харах         |                       |
| 2. Нүглийн нүдийг гурилаар        | А. Малчин хүний       |
| хуураад яанам.                    | сэтгэл тэнийдэг.      |
| 3. Мордохын хазгай                | Д. Эхнээсээ бүтэхгүй  |
| 4. Бушуу туулай борвиндоо баастай | С. Төгс хийх          |

3. Эхээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. /2 оноо/

.....  
.....

4. Зөв харгалзуулаарай. /2 оноо/

- |  |            |
|--|------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. -аар4   |
| 2. Авиа дуурайх үг                               | б. түс түс |
| 3. Дүрс дуурайх үг                               | в. -дуу2   |
| 4. Түгээл тооны нэр бүтээх дагавар               | г. цоо     |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай. /2 оноо/  
амьсгалах+аас.....


..... Холбогдох дүрэм

.....  
.....  
.....

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй. /5 оноо/

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

7. Дараах эхийг хөрвүүлээрэй. /5 оноо/



## МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

## Б ХУВИЛБАР

## УР УХААНААС ГЭРЭЛ ГЭГЭЭ ЦАЦАРНА

Уран бүтээлчид үе үеэрээ төрдөг нь жам биз. Ү. Ядамсүрэн нь зөвхөн зураач төдийгүй урлаг судлаач, сурган хүмүүжүүлэгч хүн байв.

Ядамсүрэн гуайн 1952 онд зурсан “Өвгөн хуурч” бүтээл нь Дели хотноо зохион байгуулсан олон улсын үзэсгэлэнгээс тэргүүн шагнал хүртсэн юм. Тэрээр хүний нүүр царай, ялангуяа гар хурууг маш сайхан зурдаг. Түүний бүтээсэн хөргүүд ямагт залуухан, цоглог, цэвэр цэмцгэр, ганган хээнцэр хүмүүс байдаг. “Өвгөн хуурч”-ийг ажиглаад байхад дүрийн царай төрх, нүд, зовхи, сахал, дээлийнх нь хээ, буржгар цагаан үсний ширхэг бүрийг маш нарийн дүрсэлсэн байдаг.

Ядамсүрэн гуай өөрөө юмыг их л няхуур боддог, ухаалаг сэтгэдэг, нямбай төдийгүй ганган хээнцэр, цэвэр цэмцгэр хүн байлаа. Өвөлдөө хүрэн өнгийн пүүсүү гадартай, халиу дотортой дээл өмсөн, минжин үсээр эмжсэн дэрвэгэр талтай, оройдоо том сампин зангидсан өндөр малгай духдуулан явдаг сан... Уран Жүрмэдийн хийсэн ногоон сарьсан хавчаартай, товгор хээ цохисон хүрэн өнгийн монгол гутал өмсөнө. Тэр ямагт янз бүрийн чамин хийцтэй үнэт чулуун хөөрөг бүхий даалин өвөртлөөд, таарсан хүмүүстэй тамхилдаг зантай. Хэдийгээр наян насыг зооглоод явж байгаа ч залуугийн ааг омог, хүч чадал нь биендээ багтаж ядан оволзож, урлахуйн их сэтгэл нь цээжин дотор нь дүрэлзэж яваа уран бүтээлч юм...

Түүний уран бүтээлийн баялаг амьдрал нэг ёсны нэвтэрхий толь юм.

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичнэ үү. \2 оноо\

.....  
 .....

2. Дараах хэлцүүдийг утга санаатай нь зөв харгалзуулаарай? /2 оноо/

- |                              |                        |
|------------------------------|------------------------|
| 1. Алтан аяганаас ус уух     | A. Санаа нийлэх        |
| 2. Айхын бараа идэхийн нэмэр | B. Азтай               |
| 3. Гэдсэндээ хөлөө хийлцэх   | C. Ямарч нэмэргүй      |
| 4. Ганзага нийлэх            | D. Хоорондоо муудалцах |

3.Эхээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. \2 оноо\

.....  
 .....

4. Зөв харгалзуулаарай. \2 оноо\

- |  |            |
|--|------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. -уул2   |
| 2. Авиа дуурайх үг                               | б. тас няс |
| 3. Дүрс дуурайх үг                               | в. -втар4  |
| 4. Түгээл тооны нэр бүтээх дагавар               | г. бут     |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай. /2 оноо/

зангидсан+ыг.....

.....

Холбогдох дүрэм

.....

.....

.....

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 40-50 үгэнд багтаан бичээрэй. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Үндэсний бичгээс кириллд бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

